



1/6/2023

**ТУС ЦАГДААГИЙН ГАЗАРТ
2022 ОНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ
ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН МЭДЭЭ**

Танилцуулах нь:

ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА
А.АМАРБАТ ТАНАА

Танилцуулга

Нэг. ХҮЛЭЭН АВЧ ШАЛГАСАН ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ

1.1 Тус Цагдаагийн газарт 2022 онд иргэн, аж ахуйн нэгжээс 4005 дуудлага мэдээлэл хүлээн авч өмнөх сарын үлдэгдэл 49 нийт 3956 гомдол, мэдээлэл шалгасан нь өмнөх оны мөн үеийнхээс 552 буюу 16.0 хувиар өссөн.

Гэмт хэргийн шинжтэй 854, зөрчлийн шинжтэй 3151 гомдол мэдээллийг тус тус хуулийн хугацаанд шалгаж шийдвэрлэсэн байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлт



Зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлт



Гэмт хэргийн шинжтэй 19, зөрчлийн шинжтэй 23 нийт 42 гомдол, мэдээлэл буюу нийт шалгасан гомдол, мэдээллийн 1.0 хувь нь шийдвэрлэгдээгүй буюу хуулийн хугацаанд шалгаж байна.

1.2 Хүлээн авсан гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацааг харуулбал:




Хоёр. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

2.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:

Аймгийн хэмжээнд 287 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 48 нэгжээр буюу 20.1 хувиар өссөн. Гэмт хэргийн илрүүлэлт 79.6 хувьтай байгаа нь урьд оны мөн үеэс 5.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хөнгөн гэмт хэрэг 225, хүнд гэмт хэрэг 62 бүртгэгдсэн. Хөнгөн хэргийн илрүүлэлт 82.4 хувьтай, хүнд хэргийн илрүүлэлт 71.9 хувьтай.


2.2 2022 онд бүртгэгдсэн гэмт хэрэг: /нутаг дэвсгэрээр/:




Нийт гэмт хэргийн 128 буюу 44.5 хувь нь аймгийн төвд, 159 буюу 55.4 хувь нь сумдын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн байна.

Аймгийн төвд үйлдэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 37 нэгжээр буюу 28.9 хувиар сумдын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг 11 нэгжээр 6.9 хувиар тус тус өсчээ.


2.3 Бүртгэгдсэн гэмт хэргийн газар нутгаар нь авч үзвэл:



2.4 Бүртгэгдсэн гэмт хэрэг /хэргийн ангиллаар/:



2.5 Гэмт хэргийн бүтцэд хамгийн өндөр хувь эзэлж буй гэмт хэргийн төрөл:




2.6 Бүртгэгдсэн зарим гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/:

№	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт бууралт нэгжээр	Өсөлт бууралт хувиар	
		2021. XII	2022. XII			
1	Бүх гэмт хэрэг	239	287	48	20.1	
2	Хүний амьд явахын эрхийн эсрэг 10.1-10.6	3	2	-1	-33.3	
	Үүнээс	Санаатайгаар 10.1	2	0	-2	-100
		Болгоомжгүйгээр хохироох 10.6	1	1	Ижил түвшинд	
		Бусдыг амиа хорлоход хүргэх 10.4	0	1	1	100
3	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 11.1-11.7	66	105	39	59.1	
4	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг 12.1-12.5	7	10	3	42.9	
	Үүнээс	Хүчиндэх 12.1	6	8	2	33.3
		Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах 12.2	0	1	1	100
		16 насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх 12.5.2	1	1	Ижил түвшинд	
	Хохирогчийг насны байдлаар	17 хүртэлх буюу хүүхэд хохирсон	4	6	2	50.0
		18 дээш насны	3	4	1	33.3
5	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг 13.1-13.13	1	0	-1	-100	
6	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг 14.1-14.9					
7	Эрүүл мэндийн эсрэг 15.1-15.6					
8	Хүүхдийн эсрэг 16.1-16.11					
9	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 17.1-17.12	121	127	6	5.0	
	Хулгайлах гэмт хэрэг 17.1	39	41	2	5.1	
	Дээрэм 17.2	0	3	3	100	


	Залилах 17.3	19	28	9	47.4	
	Эд хөрөнгө устгаж, гэмтээх 17.8	2	3	-1	50.0	
	Хөрөнгө завших 17.4	1	3	3	3 дахин	
	Алдаатай гүйлгээ, андуурсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, мал завших 17.5	9	11	2	22.2	
	Тээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүй авах 17.7	0	1	1	100	
	Бусдын хөрөнгө устгаж гэмтээх, үрэгдүүлэх 17.11	3	2	-1	-33.3	
	Мал хулгайлах 17.12	48	34	-14	-29.2	
10	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 20.1-20.16	3	0	-3	-100	
11	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 23.1-23.7	4	15	11	3.7 дахин	
12	Хүрээлэн байгаа орчны эсрэг 24.1-24.9	19	6	-13	-68.4	
	Үүнээс	Хууль бусаар мод бэлтгэх 24.6	15	3	-12	-80.0
		Хууль бусаар ан агнуур 24.5	3	3		Ижил түвшинд
		Хууль бусаар ашигт малтмал олборлох 24.2	1	0	-1	-100
		Химийн хорт, аюултай/б хууль бусаар эргэлтэнд оруулах 24.3				
13	Тээврийн хэрэгсэл хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 27.1-27.11	14	21	7	50.0	
14	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг /28.1-28.19/	1	1		Ижил түвшинд	

2.7 Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг:



2.8 Гэмт хэрэг үйлдсэн байдал:

Бүртгэгдсэн гэмт хэргийн 129 буюу 44.9 хувь нь согтуугаар, 16 буюу 5.6 хувь нь эмэгтэй хүн оролцож, 44 буюу 15.3 хувь нь гудамж талбайд, 96 буюу 33.4 хувь нь гэр орон сууцанд тус тус үйлдэгдсэн байна.




Гурав. ГЭМТ ХЭРГИЙН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь:

Гэмт хэргийн илрүүлэлт 79.6 хувьтай байгаа нь урьд оны мөн үеэс 5.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Улсын хэмжээнд илрүүлэлт 54.2 хувь, нийслэлд 52.0 хувьтай байна. Улсын дундажаас 25.4 хувиар их байна



3.2 Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах тогтоол үйлдэгдээгүй 44 гэмт хэрэг:



Дөрөв. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДОГЧ


4.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн:

Нийт 269 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 61 нэгжээр буюу 29.3 хувиар өссөн.

Холбогдогчид нь эмэгтэй хүн үйлдсэн 15, хүүхэд үйлдсэн гэмт хэрэг 22 тус тус бүртгэгдсэн.


4.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс:

		2021.XII	2022.XII
Гэмт хэрэг үйлдсэн бүх хүн		208	269
үүнээс:	Эмэгтэй	18	15
Нас	15 хүртэлх	5	14
	16-17	2	8
	18-24	44	40
	25-29	35	42
	30-34	34	51
	35-39	30	39
	40-44	21	37
	45-49	11	20
	50-дээш	26	18



Тав. ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ, ХОХИРЛЫН ХЭМЖЭЭ

5.1 Хохирсон хүн, хуулийн этгээд:



Гэмт хэргийн улмаас 292 хүн хохирч, 117 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт хохирогч 47 нэгжээр буюу 19.2, гэмтсэн хүн 43 нэгжээр буюу 58.1 хувиар өссөн байна.

5.2 Учирсан хохирол: Иргэн, хуулийн этгээдэд учирсан 1.101.7 сая төгрөгийн хохирлын 753.7 сая төгрөг буюу 68.4 хувийг нөхөн төлүүлж, 57.6 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.

Зургаа. ЗӨРЧИЛ

6.1 Нийт бүртгэгдсэн зөрчил:

Тус цагдаагийн газарт нийт 24523 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5129 нэгжээр буюу 26.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

6.2 Бүртгэгдсэн зөрчлийн ангилал:

Зөрчил гаргасан 23371 иргэн, 16 хуулийн этгээдийг 1.070.375.5 сая төгрөгөөр торгосон. Үүнээс бэлэн бус торгуулиар 21600 зөрчилд 545.418.500 төгрөгний торгууль ногдуулсан.

423 хүнийг баривчлах, 739 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус ногдуулсан байна.

16 Хуулийн этгээдэд торгууль ногдуулсан

423 Баривчилсан

739 Тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасаж, торгосон

23371 Хүнд торгууль ногдуулсан

6.3 Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдсон этгээдийг эрүүлжүүлэх үйл ажиллагаа:

39 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 332 буюу 89.5 хувиар буурчээ. Нийт эрүүлжүүлэгдсэн хүний 38 буюу 97.4 хувь нь эрэгтэй, 1 буюу 2.5 хувь нь эмэгтэй хүн байна.

6.4 Сүүлийн 5 жилд эрүүлжүүлэгдсэн хүний тоо:



НЭГТГЭСЭН:

МЭДЭЭЛЭЛ СУДАЛГААНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,

ЦАГДААГИЙН ХОШУУЧ

М.ОДХҮҮ